



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; <http://www.city.audit.mn>

2018.02.23 № 669

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГА, ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ Ж.ГАНБОЛД
ТАНАА

Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын
хорооны 2017 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

С.ЭНХБААТАР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; <http://www.city.audit.mn>

2018. 02. 23 № 670
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГА, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Ж.ГАНБОЛД
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



С.ЭНХБААТАР

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Б.Баттуяа

Дэд дарга, тэргүүлэх аудитор
Утас 327744

Д.Отгонбаяр

Санхүүгийн аудитын
I хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
Утас 315558

М.Лхагвасүрэн

Аудитор
Утас 315093

ТАБ-ын нэр: Нийслэл дэх
Төрийн аудитын газар

Хаяг: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1,
Амарын гудамж 2, Соёлын төв
өргөө, "Г" корпус, 4-5 дугаар
давхар

Цахим хуудас: city.audit.mn

2018 оны 2 дугаар сарын 23

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийгдсэн төсвийн

гүйцэтгэлийн тайлан

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ННБТСХ	Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хороо
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
АОУС	Аудитын олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ННБТСХ	Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хороо
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
АОУС	Аудитын олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Залруулгадаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны 2017 оны санхүүгийн тайланд НТАГ-2018/613/СТА-ТШЗ баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Биеийн тамир спортын, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд АОУС-ын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

ННБТСХ-ны 2017 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн төсвийн байгууллагын НБББББ-ийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

ТШЗ нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь НТАГ-ын үүрэг юм.

Уг байгууллагын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн НТАГ-ын санхүүгийн аудитын I хэлтсийн II багийн аудитор М.Лхагвасүрэн 2018 оны 02 дугаар сарын 23-нд гүйцэтгэв.

Тус хэлтэс нь 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 01 дүгээр сарын 24-нд 01/16 тоот албан бичгээр хуулийн хугацаанд НТАГ-т ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 02 дугаар сарын 23-нд ННБТСХ-ны удирдлагад хүргүүлж байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

ННБТСХ-ны ТШЗ нь Төсвийн, Биеийн тамир спортын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Хөдөлмөрийн, Нийгмийн даатгалын, Төрийн албаны тухай хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Биеийн тамир, спортын тухай хуулийн 1.1. "биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт үйл ажиллагаа, эрх зүйн үндсийг тодорхойлж, биеийн тамир, спортыг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тухайн байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий ТШЗ-тай байна" гэж заасны дагуу ННБТСХ-ны дарга нь ТШЗ-ийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус байгууллагын 2017 оны төсвийг БСШУС-ын багцаас санхүүжүүлж, Нийслэлийн төрийн сангаар дамжуулан олгожээ.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 8-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцаж, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар боловсруулж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хурлын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Нийслэлийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажиллажээ.

Тус байгууллагын ТШЗ нь 2017 онд нийслэлийн төсвөөс урсгал зардалд 410 578.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснийг бүрэн авч, гүйцэтгэлээр 410 058.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 519.4 мянган төгрөгийг нийслэлийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар НЗДТГ-аас 256 562.2 мянга, “Улаанбаатар Марафон-2017” арга хэмжээний зардлын хураамжид 17 622.8 мянга нийт 274 185.0

мянган төгрөгийн орлого орсноос гүйцэтгэлээр 273 721.5 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 463.5 мянган төгрөгийг нийслэлийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2017 оны 11 дүгээр сард нийцлийн аудит хийгдсэн.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлогын эхний үлдэгдлийг илүү тайлагнасан, биет бус хөрөнгийг зардлаар тайлагнасан, нийгмийн даатгалын өглөг дутуу тайлагнасан зэрэг нь хууль тогтоомж, заавар журам НББОУС зөрчигдөх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 517 358.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, орлого, авлага, өглөг, бараа материал, цалин хөлс зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан горим, сорил нь тус байгууллагын нийт орлогын 75.6%, нийт зардлын 75.2%, мөнгөн хөрөнгийн 75.6%, нийт хөрөнгийн 100.0%-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад төсвийн тухай хууль зөрчсөн **материаллаг бус** хэмжээний 2 712.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг зөрчиж, мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлогын эхний үлдэгдлийг 1 069.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
 - Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.
- НББОУС-38.21.дэх заалтыг зөрчиж, 1 500.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг зардлаар тайлагнасан
 - Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг зөрчиж, нийгмийн даатгалын өглөг 143.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
 - Шийдвэрлэсэн: Зөрчлийг гаргахгүй байх зөвлөмж өгсөн

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг зөрчиж тооллого хийсэн боловч эд хөрөнгийн тооллогын бүртгэл баталгаажуулж гаргаагүй.
 - Шийдвэрлэсэн: Зөрчлийг гаргахгүй байх зөвлөмж өгсөн

Залруулгадаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль дүрэм мөрдөөгүйгээс гарсан 143.4 мянган төгрөгийн зөрчлийг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан ажил үйлчилгээ, бараа худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу харьцуулалтын арга хэрэглэж байгаа эсэхийг тооцоолоогүй, эрсдэлтэй байж болох асуудлыг 2018 оны завсрын аудитаар шалгахар тогтов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2 712.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 94.7% буюу 2 569.2 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 5.3% буюу 143.4 мянган төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж өглөө

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар 1 зөвлөмж өгснийг 100% хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

ННБТСХ-ны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд 5 хуудас байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ


Хянасан:

Дэд дарга, тэргүүлэх аудитор

Б.Баттуяа

Санхүүгийн аудитын I хэлтсийн дарга
бөгөөд аудитын менежер

Д.Отгонбаяр



Бэлтгэсэн:

Аудитор

A large, stylized handwritten signature in black ink, likely belonging to the auditor.

М.Лхагвасүрэн

2018 оны 2 дугаар сарын 23

Үйлчлүүлэгч байгууллагын хариу



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРОО


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 15, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны IV байр
Утас: 31-27-85, Факс: (976-11) 32-89-77
E-mail: it@sport.ub.gov.mn
http://www.sport.ub.gov.mn

2018.02.23 № 01/49
танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Манай байгууллагын 2017 оны санхүүгийн
тайланд баталгаажуулах аудитаар илэрсэн
зөрчилтэй танилцлаа, цаашид ирсэн зөвлөмжийг
хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500051

D:\2018\2018 alban toot\Alban toot A5-2018.docx

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРООНЫ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Тайлагнал12

Асуудал 2

Биет бус хөрөнгө.....12

Асуудал 3

Бараа материал.....13

Асуудал 4

Цалин13

2018 оны 2 дугаар сарын 23

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРООНЫ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Тайлагнал12

Асуудал 2

Биет бус хөрөнгө.....12

Асуудал 3

Бараа материал.....13

Асуудал 4

Цалин13

2018 оны 2 дугаар сарын 23

Менежментийн захидал

НТАГ нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ННБТСХ-ны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

НТАГ-ын энэхүү зөвлөмж танай бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ННБТСХ-ны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Тайлагнал

Тэргүүлэх ач холбогдол №1

НТАГ-ын ажиглалт

- Мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлогын эхний үлдэгдлийг 1 069.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл НББ-ийн зарчим-ын 5.1.4. "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн

НТАГ-ын зөвлөмж

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах;

Эрсдэлүүд

- Холбогдох хууль тогтоомж мөрдөж ажиллахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

- Төсвийн захирагчийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Асуудал 2: Биет бус хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №1

НТАГ-ын ажиглалт

- Биет бус хөрөнгө 1 500.0 мянган төгрөгийг зардлаар тайлагнасан нь НББОУС-38.21. Биет бус хөрөнгийн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө: "хэрэв тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг аж ауйн нэгж хүртэх магадлалтай бол" заалтыг зөрчсөн.

НТАГ-ын зөвлөмж

- НББОУС-ын холбогдох заалтыг мөрдөж ажиллах;

Эрсдэлүүд

- НББОУС, болон заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

- Төсвийн захирагчийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Асуудал 3: Бараа материал

Тэргүүлэх ач холбогдол №1

НТАГ-ын ажиглалт

- Нийгмийн даатгалын өглөг дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл НББ-ийн зарчим-ын 5.1.4. "үнэн зөв байх" заалт

НТАГ-ын зөвлөмж

- НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах;

Эрсдэлүүд

- Холбогдох хууль тогтоомж мөрдөж ажиллахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

- Төсвийн захирагчийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Асуудал 4: Цалин

Тэргүүлэх ач холбогдол №1

НТАГ-ын ажиглалт

- Тооллого хийсэн боловч эд хөрөнгийн тооллогын бүртгэл баталгаажуулж гаргаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх заалт "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх";

НТАГ-ын зөвлөмж

- ТБОНӨТХ-ийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах;

Эрсдэлүүд

- Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

- Төсвийн захирагчийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ


Хянасан:

Дэд дарга, тэргүүлэх аудитор

Б.Баттуяа

Санхүүгийн аудитын I хэлтсийн дарга
бөгөөд аудитын менежер

Д.Отгонбаяр



Бэлтгэсэн:

Аудитор

М.Лхагвасүрэн

2018 оны 2 дугаар сарын 23

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,797,975.00	6,162,972.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,797,975.00	6,162,972.00
354	Хангамжийн материал	3,797,975.00	6,162,972.00
35410	Бичиг хэргийн материал	502,500.00	776,500.00
35420	Аж ахуйн материал	3,295,475.00	5,386,472.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,621,147.58	15,831,306.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,621,147.58	15,831,306.02
392	Биет хөрөнгө	19,621,147.58	14,331,306.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,376,202.00	22,376,202.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,376,202.00	-22,376,202.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,853,379.90	42,853,379.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,232,232.32	-28,522,073.88
393	Биет бус хөрөнгө	00.00	1,500,000.00
39301	Програм хангамж	280,000.00	1,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-280,000.00	-280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	23,419,122.58	21,994,278.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,419,122.58	21,994,278.02
51	Засгийн газрын хувь оролцоо	23,419,122.58	21,994,278.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	58,011,395.49	58,011,395.49
51101	Өмч: - төрийн	58,011,395.49	58,011,395.49
512	Хуримтлагдсан үр дүн	-34,592,272.91	-36,017,117.47
51210	Өмнөх үеийн үр дүн	-34,592,272.91	-34,592,272.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,424,844.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	23,419,122.58	21,994,278.02

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	695,655,627.02	684,763,260.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,669,215.02	00.00
121	Хөрөнгийн орлого	2,600,000.00	00.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	2,600,000.00	00.00
124	Зээлийн орлого	69,215.02	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	692,986,412.00	684,763,260.96

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	369,565,412.00	410,578,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	369,565,412.00	410,578,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	323,421,000.00	274,184,960.96
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	305,021,000.00	256,562,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,400,000.00	17,622,760.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	697,589,977.51	686,188,105.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	686,348,020.49	681,505,205.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	686,348,020.49	681,505,205.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,484,529.00	98,924,382.00
210101	Үндсэн цалин	107,484,529.00	98,924,382.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,817,953.00	11,833,344.00
210201	Тэтгэврийн даатгал	6,437,453.00	7,906,710.00
210202	Тэтгэмжийн даатгал	672,400.00	688,110.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,344,800.00	949,110.00
210204	Ажилгүйдлийн даатгал	672,400.00	318,638.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,690,900.00	1,970,776.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,167,770.00	11,834,500.00
210302	Түлш, халаалт	3,446,600.00	00.00
210304	Байрны түрээс	9,721,170.00	11,834,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,821,891.00	8,618,227.00
210401	Бичиг хэрэг	886,900.00	1,489,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,192,580.00	5,076,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,742,411.00	2,052,867.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	540,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	540,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,876,256.00	280,135,805.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	314,616,256.00	276,063,241.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	906,400.00	3,514,364.00
210807	Газрын төлбөр	353,600.00	558,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,179,621.49	269,618,947.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	221,954,421.00	264,329,106.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,225,200.49	5,289,841.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,241,957.02	4,682,899.96

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	3,700,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,640,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.00	3,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,241,957.02	982,899.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,241,957.02	982,899.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,934,350.49	-1,424,844.56
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,934,350.49	-1,424,844.56

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	694,055,627.02	684,763,260.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,069,215.02	00.00
124	Зээлийн орлого	1,069,215.02	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	692,986,412.00	684,763,260.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	369,565,412.00	410,578,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	369,565,412.00	410,578,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	323,421,000.00	274,184,960.96
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	305,021,000.00	256,562,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,400,000.00	17,622,760.96
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	694,055,627.02	683,263,260.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,055,627.02	683,263,260.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,813,670.00	678,580,361.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,484,529.00	98,608,100.00
210101	Үндсэн цалин	99,884,529.00	91,333,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,600,000.00	7,274,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,817,953.00	10,846,900.00
210201	Тэтгэврийн даатгал	7,517,753.00	6,920,266.00
210202	Тэтгэмжийн даатгал	537,400.00	688,110.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,074,800.00	949,110.00
210204	Ажилгүйдлийн даатгал	537,400.00	318,638.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,150,600.00	1,970,776.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,167,770.00	11,999,500.00
210302	Тулш, халаалт	3,446,600.00	00.00

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

210304	Байрны түрээс	9,721,170.00	11,999,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,168,323.00	8,914,424.00
210401	Бичиг хэрэг	1,348,000.00	1,785,497.00
210402	Тээвэр, шатахуун	6,192,580.00	5,076,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,627,743.00	2,052,867.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	00.00
210602	Тавилга	2,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	310,194,924.00	283,203,456.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,489,076.00	279,430,367.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,352,248.00	3,214,889.00
210807	Газрын төлбөр	353,600.00	558,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,980,171.00	264,467,981.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,980,171.00	264,467,981.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,241,957.02	4,682,899.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	3,700,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,241,957.02	982,899.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,241,957.02	982,899.96

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,011,395.49	00.00	-15,387,651.68	00.00	42,623,743.81
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,011,395.49	00.00	-15,387,651.68	00.00	42,623,743.81
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,149,067.57	00.00	-13,149,067.57
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,011,395.49	00.00	-34,592,272.91	00.00	23,419,122.58
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,011,395.49	00.00	-34,592,272.91	00.00	23,419,122.58
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,424,844.56	00.00	-1,424,844.56
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,011,395.49	00.00	-36,017,117.47	00.00	21,994,278.02

/төгрөгөөр/

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн / илүү +, дутуу -/	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	410,578,300.00	410,058,894.00	(519,406.00)	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	410,578,300.00	410,058,894.00	(519,406.00)	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,860,700.00	406,358,894.00	(501,806.00)	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,608,100.00	98,608,100.00	-	100.0
210101	Үндсэн цалин	91,333,900.00	91,333,900.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,274,200.00	7,274,200.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,846,900.00	10,846,900.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	6,920,266.00	6,920,266.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	688,110.00	688,110.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	949,110.00	949,110.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	318,638.00	318,638.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,970,776.00	1,970,776.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,999,500.00	11,999,500.00	-	100.0
210304	Байрны түрээс	11,999,500.00	11,999,500.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,107,100.00	8,914,424.00	(192,676.00)	97.9
210401	Бичиг хэрэг	1,811,600.00	1,785,497.00	(26,103.00)	98.6
210402	Тээвэр, шатахуун	6,200,000.00	5,076,060.00	(1,123,940.00)	81.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,095,500.00	2,052,867.00	957,367.00	187.4

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРООНЫ 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,042,900.00	33,741,989.00	(300,911.00)	99.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000,000.00	29,968,900.00	(31,100.00)	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,215,600.00	3,214,889.00	(711.00)	100.0
210807	Газрын төлбөр	827,300.00	558,200.00	(269,100.00)	67.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	242,256,200.00	242,247,981.00	(8,219.00)	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	242,256,200.00	242,247,981.00	(8,219.00)	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,717,600.00	3,700,000.00	(17,600.00)	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,717,600.00	3,700,000.00	(17,600.00)	99.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,717,600.00	3,700,000.00	(17,600.00)	99.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	410,578,300.00	410,058,894.00	(519,406.00)	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	410,578,300.00	410,058,894.00	(519,406.00)	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	410,578,300.00	410,058,894.00	(519,406.00)	99.9
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	8	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.0

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		273,721,467.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		273,721,467.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		273,721,467.00
2107	Томилолт, зочны зардал		540,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		540,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		250,961,467.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		250,961,467.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		22,220,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		22,220,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		273,721,467.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		273,721,467.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		256,562,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		17,159,267.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		